

ДИПЛОМАТ БАРИМТ БИЧГИЙН ОРЧУУЛГЫН АСУУДАЛД

Д.Долгорсүрэн⁶⁷

Abstract: *Since 1990s, in the developing international relations, cultural and diplomatic exchanges between Mongolia and the world community, the linguistic contact, especially the diplomatic language skills between Mongolian and English languages has been increasingly expanded. In diplomatic and legal documents many words have Latin and French origin. There are a lot of abbreviations and conventional symbols, and the most noticeable feature of grammar is the compositional pattern. Every diplomatic document has its own stereotyped form. Therefore, through this article, we look into how those stereotyped forms, abbreviations and conventional symbols are used in diplomatic documents. This article presents a number of issues concerning teaching principles of diplomatic translation, and gives examples based on some documentation.*

Keywords: *diplomatic documents, stereotyped forms, abbreviations and conventional symbols*

XX зууны сүүлч, XXI зууны эхээс Монгол Улсын гадаад харилцаа, хамтын ажиллагаа улам эрчимжиж, олон улсын харилцаанд гүйцэтгэх үүрэгтэй нь холбогдуулан дипломат баримт бичиг боловсруулах, орчуулах хэрэгцээ шаардлага нэмэгдсээр байна. Олон улсын харилцааны гол хэлний нэг болох англи хэлийг сайн сурах, эзэмших боломжтой болохын хирээр зөв оновчтой орчуулахад анхаарч, орчуулгын чанарт тавигдах шаардлага нь илүү өндөрсөж байна. Өнөө цагт англи хэлнээс монгол хэл рүү, монгол хэлнээс англи хэл рүү аливаа бичвэрийг, ялангуяа дипломат баримт бичгийг орчуулахад, мөн орчуулах аргыг заахад анхаарах зарим асуудлыг энд авч үзье.

Дипломат баримт бичиг нь аливаа улс орны дотоод гадаад харилцаанд нөлөөлдөг, олон улсын тавцанд тухайн улсын байр суурь, нэр хүндийг илтгэдэг ихээхэн ач холбогдолтой зүйл бөгөөд улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, оршин тогтнохуйд нөлөө үзүүлдэг чухал албан бичигт тооцогддог. (Цолмон, 2010) Тийм учраас дипломат баримт бичгийн орчуулгын асуудал багш, орчуулагч, судлаач, хэл шинжээчдийн анхаарлыг татаж, орчуулгын чанарт анхаарч, ихэд нухацтай ул суурьтай хандаж ирсэн билээ.

Дипломат баримт бичгүүд дэх зарим үг хэллэг, нэр томьёо, товчлол зэргийг орчуулах арга аргачлалын тухай авч үзэхийн өмнө дипломат баримт бичиг гэдэгт чухам юуг хамааруулж авч үздэгийг товч тайлбарлая.

⁶⁷ Доктор /Ph.D./, МУИС, ШУС, ХУС-ын ГХТ

Дипломат баримт бичгийн түгээмэл хэлбэрүүдэд дараах баримт бичгүүдийг оруулж тооцдог. Үүнд:

- Ноот бичиг – Notes /A Note Verbale (first person’s note, third person’s note, protest note, collective note, identical note, etc..)
- Меморандум – A Memorandum
- Санамж бичиг – Aide-memoire
- Албан захидал – Official letters (letter of introduction, letter of protection, letters of commission, letters of credence, letters of recall, letter of request, letter rogatory, etc.)
- Тунхаглал/тунхаг бичиг – Declaration
- Хамтарсан мэдэгдэл/Хамтарсан албан мэдээ – Коммунике – Communiqué
- Демарш – мэдэгдэл (/дипломатчид суугаа улсдаа аливаа асуудлын талаар /аман болон бичгийн хэлбэрээр/ эсэргүүцсэн, гомдоллосон, эсвэл, тулган шаардсан байдлаар мэдэгдэл хийхийг/гаргахыг энэ нэр томъёогоор илэрхийлдэг.) /албан ёсны байр суурь, үзэл бодлоо илэрхийлсэн баримт бичиг/ (Цолмон, 2010)

Эдгээр баримт бичгүүд нь тус бүрдээ өөр өөрийн бичлэгийн хэв маяг, онцлог, эхлэл төгсгөлтэй, тогтсон үг хэллэгийн хувьд багагүй ялгаатай байдаг. Өөрөөр хэлбэл, дипломат баримт бичиг, албан захидлыг үйлдэх, бичих тодорхой дараалал, хэв загвар гэж байдаг.

Дипломат баримт бичгийг боловсруулахад дараах үндсэн шаардлагуудыг тавьдаг. Үүнд:

- ❖ Эрэмбэ дараалалтай, утгын авцалдаатай байх
- ❖ Санаагаа энгийн агаад даруу үг хэллэгээр илэрхийлэх
- ❖ Үнэн бодит байдалд нухацтай нийцүүлсэн байх
- ❖ Тааламжтай, боловсон үг хэллэгээр эхэлж, дуусгадаг байх
- ❖ Тохирох үг хэллэгийг оновчтой зөв сонгох

Аливаа бичиг баримт, бичвэрийг орчуулахдаа ямар чиглэлийн, аль салбарын орчуулга болох эсэхээс нь хамаарч орчуулгын төрөл зүйлийг нь тодорхойлдог. Ерөнхийдөө орчуулгын дараах төрөл зүйлүүд байдаг. Үүнд:

- Нийгэм, улс төрийн зохиол бүтээлийн орчуулга
- Сонин сэтгүүлийн өгүүлэл, нийтлэл, мэдээллийн хэрэглэгдэхүүний орчуулга
- Шинжлэх ухаан техникийн зохиол бүтээлийн орчуулга
- Уран зохиолын орчуулга
- ❖ Дипломат албан бичиг баримт ба хууль эрхийн актын орчуулга

Дипломат баримт бичгийн орчуулгын онцлог

Орчуулгын төрөл зүйл дотроо хамгийн сүүлд буюу “дипломат албан баримт бичиг ба хууль эрхийн актын орчуулга” гэсэн ангилалд ордог дипломат албан бичгийн хэл найруулга нь дараах онцлогтой. Үүнд:


- Үе үеийн турш тогтсон хатуу стандарчлалтай
- Тодорхой нэр томъёо, нэрийн цогц, хураасан үгс ихтэй /үндсэн дээр, зорилгоор, ... -тэй холбогдон г.м/
- Товч тодорхой хэв загвартай /иргэний үнэмлэх, диплом, төрсний гэрчилгээ г.м/
- Хэл найруулгын өнгө аяс, үгсийн зохилдлого нь нягт, хэлний хэмнэлийн зарчмыг баримталдаг бөгөөд логик дараалал чухал үүрэгтэй байдаг.
- Бичлэгийн аяс хүүрнэлийн шинжтэй боловч угсруулан тоочих арга зонхилдог
- Сэтгэл хөдлөлийн өнгө аяс бараг илэрдэггүй

Дипломат баримт бичигт төлөөллийн аргыг түгээмэл хэрэглэдэг. Жишээ нь: “Downing Street” гэвэл энэ нь Их Британий засгийн газрыг /тэр гудамжинд Их Британий ерөнхий сайдын өргөө, Гадаад явдлын яам байрладаг/ хэлж байгаа ба “White House” гэвэл АНУ-ын ерөнхийлөгчийн байр суурийг, эсвэл, засгийн газрынх нь тухай өгүүлж байгаа хэрэг юм. Дипломат баримт бичгийн үг хэллэг, найруулгын онцлогийг орчуулга нь тусган харуулахуйц байх шаардлагатай байдаг. Дипломат баримт бичгийн орчуулга нийгэм улс төрийн орчуулга болон бусад төрлийн орчуулгаас ялгагддаг гол ялгаа нь:

- Эрхэмсэг дээд найруулга бүхий хүндэтгэлийн үг хэллэгээр илэрхийлэн бичигддэг онцлогтой. /“гүн хүндэтгэл”, “хүлцэл өчих”, “айлтгах” зэрэг/
- Үндэсний онцлог үг хэллэг, товчлол болон бичлэгийн өвөрмөц шинжтэй
- Шууд бус буюу далд /давхар утгыг өөртөө агуулж байдагт оршино. (Алтангэрэл, 2007)
- Тодорхой нэр томъёо, нэрийн цогц их хэрэглэдэг. Тухайлбал, дипломат албан баримт бичигт хураасан үг их байдаг.

Аливаа орчуулга үнэн зөв байх зарчимд тулгуурладаг бөгөөд хүний бүтээлч үйл ажиллагаа, сэтгэн бодох болон мэргэжлийн ур чадварыг илэрхийлэн харуулдаг нарийн үйл явц юм. Орчуулгыг зөв агаад оновчтой хийх нэг чухал арга зам нь хоёр хэлний хэлзүй, үгсийн сангийн утгыг сайн мэдэх явдал байдаг. Ялангуяа төрөл бус хэлүүд болох монгол, англи хэлний тухайд анхаарах ёстой бөгөөд англи хэлнээс монгол хэл рүү мэргэжлийн нэр томъёо, үг хэллэгийг орчуулахдаа аливаа үгийг үгийн сангийн утгын талаас нь авч үзэх хэрэгтэй байдаг. Ер нь ямар ч орчуулгад нийлэмж үгс, хоршоо үгс, өвөрмөц хэллэг, өгүүлбэрийн бүтэц зэргийг яг байгаа хэлбэрээр нь буулгавал, өөрөөр хэлбэл, үгчилбэл алдаа гаргах магадлал ихэсдэг.

Орчуулгын онолд үгчлэх, утгачлах, тайлбарлах гэх мэт олон аргууд байдаг. (Амар-Амгалан) Орчуулгын аргуудын харьцааг тоогоор илэрхийлэхэд дараах байдалтай байна.



Ерөнхийдөө орчуулагчид үгчлэх, хуулбарлах аргаас аль болох зайлсхийж, дүйлгэх, утгачлах, тайлбарлах аргуудыг түлхүү хэрэглэх нь аливаа орчуулгыг чанартай, оновчтой болоход ач тустай юм.

Хэл бол санааг хэлбэржүүлж, томъёолох хэрэгсэл гэдэг онолын үүднээс үзэхэд дипломат баримт, ноот бичгүүдэд тогтсон өвөрмөц үг хэллэгүүд, нэр томъёо элбэг тохиолддог билээ. Жишээлбэл: үндсэн утга нь ямар нэг зүйлийг/боломжийг алдалгүй ашиглах гэсэн утгатай **Avail yourself of sth** (formal) /– to make use of sth, especially an opportunity or offer: *Guests are encouraged to avail themselves of the full range of hotel facilities.* / гэсэн англи хэллэгийг дипломат баримт бичигт өргөнөөр хэрэглэдэг бөгөөд монгол хэл рүү орчуулахдаа гол төлөв “**энэ завшааныг ашиглан**” гэж буулгадаг.

Бүтэн өгүүлбэрээр жишээ авъя:

“The Ministry of Foreign Affairs of China avails itself of this opportunity to renew to the Ministry of External Affairs of Japan the assurances of its highest consideration” гэсэн өгүүлбэрийг орчуулахдаа “Хятадын Гадаад Хэргийн Яам нь энэ завшааныг ашиглан Японы Гадаад Явдлын Яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна”. (**энэ завшааныг ашиглан** – avails itself of this opportunity) гэж болох бөгөөд “to have the honor to inform” гэснийг “**мэдэгдэх завшаан тохиох**” гэж орчуулдаг. Энэ “**to have the honor to inform**” гэсэн хэллэгт боломж, завшаан буюу *avail, opportunity* гэсэн үгс огт байхгүй хэдий ч монгол хэл рүү буулгахдаа завшаан гэдэг үгээр дүйлгэн орчуулдаг. To have the honour to inform гэснийг “**мэдэгдэх завшаан тохиох**” гэж орчуулдаг боловч to have the honor to intimate гэсэн хэллэгийг “хичээнгүйлэн айлтгах” гэж тун ч хүндэтгэлтэй байгаагаа илэрхийлсэн маягаар орчуулдаг бөгөөд **honor** гэсэн үгийг орхидог. Энэ мэт жишээ олныг дурдаж болно.

Дипломат баримт бичигт мэргэжлийн нэр томъёоноос гадна латин, грек, франц зэрэг хэлнээс авсан үг хэллэг түгээмэл хэрэглэгддэг. Ялангуяа XVI зууны сүүлээс XVIII зууныг дуустал олон улсын харилцааны гол хэл байсан франц

хэлнээс маш олон үг, хэллэг, нэр томъёонууд дипломат баримт бичигт хадгалагдан үлдсэн байдаг бөгөөд тэдгээр нь өнөөг хүртэл олон улсын харилцааны талбарт, дипломат баримт бичигт өргөнөөр хэрэглэгдсэн хэвээр байна. Тэдгээрийг англи, монгол хэл рүү орчуулахдаа тайлбарлах, утгачлан орчуулах аргуудыг ашиглах нь зүйтэй байдаг. Дипломат баримт бичиг, албан захидлууд болон хууль эрхийн акт, гэрээ, тогтоол тогтоомжуудыг орчуулахдаа олон улсын харилцаанд хэвшил болсон, байнга хэрэглэгддэг үг хэллэгийг зөв, зохистой сонгон хэрэглэхийн зэрэгцээ албан ёсоор тогтсон нэр томъёоны стандартыг баримтлах нь зүйтэй юм.

Дипломат баримт бичигт болон дипломат албанд өргөн хэрэглэгдэж буй түгээмэл нэр томъёо, товчлолоос түүвэрлэн авч үзэхэд тэдгээрийн дийлэнх нь франц үг байгааг харж болно. Тухайлбал:

RSVP – (явуулсан урилгад) хариу өгнө үү гэсэн утгатай франц товчлол

UTC – (Coordinated Universal Time) – Greenwich Mean Time

Inst / instant – of this month – энэ сарын; as in ‘Thank you for your dispatch of the 19th instant’.

Ultimo – of last month – өнгөрсөн сарын; as in ‘Thank you for your dispatch of the 19th ultimo’.

De jure (from Latin, law) - according to the law: He held power de jure and de facto (= both according to the law and in reality)

De facto – existing as a fact although it may not be legally accepted as existing

Entente – friendly relationship – эвсэг байдал / найрсаг харилцаа

Détente – намжмал байдал / харилцаа сайжрах – détente /dei'ta:nt/

Laisser passer – /travel documents/ ≈ **diplomatic passport** - чөлөөтэй зорчих эрхийн бичиг

Nul et non avenue – (Literary) null and void/ (Traditionally) the phrase used in refusing to accept an offensive message and returning it to the sender

UNO-City – A popular name for the Vienna International Centre, opened in 1979, where the UN system has a significant presence.

Tour d’horizon /exchange of views/ – санал солилцох (Дипломатууд тодорхой асуудлаар санал солилцох гэсэн утгатай франц үг)

Red memo – a message of rebuke sent to one of its diplomats by a ministry of foreign affairs – сануулга /донгодсон бичиг/

Buffer zone – дундын / аюулгүй бүс

Ratification – соёрхон батлах

NO DIS – it stands for ‘No Distribution’;

CHOGM /summitry, or Commonwealth Heads of Government Meeting/ - Хамтын Нөхөрлөлийн Орнуудын Төрийн Тэргүүнүүдийн уулзалт

First poster /a diplomat preparing for, or already at, his or her first overseas posting/ – анхны гадаад томилгоогоо аваад буй дипломат ажилтан

Benelux – Belgium, the Netherlands, and Luxembourg

Цаашилбал дипломат албанд түгээмэл байдаг баримт бичгүүдийн нэршил болон тэдгээрт бичигддэг тогтсон зарим үг хэллэг, нэр томъёог монгол хэл рүү хэрхэн орчуулж болохыг дараах жишээгээр харуулъя.

Ехекуатур – Консулын газрыг нээн ажиллуулахыг зөвшөөрсөн албан баримт бичиг/ Консулын зөвшөөрөл

Collective Note - хамтарсан ноот бичиг

First person's note - хувийн ноот

third person's note - төлөөний ноот

acte finale /final act/ - төгсгөлийн баримт бичиг

Chief of Protocol - Төрийн Ёслолын Албаны дарга

Career diplomat - мэргэжлийн дипломат

Ёслолын Хэлтэс – Protocol Department

to request to kindly assist in . . . - . . . - д туслахыг хүсэх

presents its compliments - талархал илэрхийлэхийн ялдамд

to take a firm line on . . . - . . . – ны талаар/тухайд хатуу байр суурьтай байх

Ambassador Extraordinary and Plenipotentiary - Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд

Civilian police – Энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй цагдаагийн бие бүрэлдэхүүн

Blue Berets – НҮБ-ын энхийг сахиулагчид (Монгол хэлэнд энэ холбоо үгийг “хөх дуулгатнууд” хэмээн тун ч сонирхолтой агаад уран яруу орчуулдаг)

Мөн нэмж хоёр жишээ авч үзье:

1. Eleventh hour /deadline/ – stopping the clock – хэлэлцээрийн цаг дууссаныг илэрхийлдэг хэллэг

2. to renew to . . . the assurances of its highest consideration - . . . –д нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлэх

Монголоос англи руу орчуулсан дараах жишээнүүдийг харья:

- олон нийтийн зүгээс их дэмжлэг хүлээх – to have a lot of support on the ground
- итгэмжлэх жуух бичиг өргөн барих – to present /one's/ letter of credence (credentials)
- ижил байр суурьтай байх – to take the same line
- иж бүрэн түншлэл – comprehensive partnership
- тохиролцоонд хүрэх – reach an agreement
- цаг хугацаа болон газрыг товлох – designating the date and place
- хүлцэл өчих – to send one's regrets and apologies


Энэ мэт маш олон жишээ дурдаж болно.

Дипломат орчуулга бол маш онцгой чухал орчуулга юм. Энэ нь зөвхөн орчуулагчийн мэдлэг чадварыг харуулдаг төдий биш, харин улс эх орны нүүр царай, нэр хүндийг илтгэдэг. Тиймээс дипломат орчуулагчдад, ер нь дипломат баримт бичгийн орчуулга хийж буй хэнд ч бай хатуу шаардлага тавьдаг. Тэд орчуулга хийх хэлээ маш сайн мэддэг байх ёстой бөгөөд тухайн хэлүүд дэх олон янзын аялгыг сайтар эзэмших ёстой төдийгүй, олон улсын харилцааны нэр

томьёо, дипломат ажиллагаатай холбоотой латин үг хэллэгүүд, мөн дэлхийн түүхэнд холбогдох гол үйл явдлуудыг сайн мэддэг байх шаардлагатай болдог. Аман орчуулга хийх үед сэргэлэн овсгоотой байх чадвар нэн хэрэг болдог. Учир нь шууд орчуулж болохооргүй үг хэллэгүүдтэй их таардаг бөгөөд ялангуяа маш хэцүү асуудлыг хэлэлцэх, мэдээлэх үед хэлц үг, өвөрмөц хэллэгүүд, шинээр үүсэн бий болсон үг хэллэг, нэр томьёонууд гарч ирдэг. Түүнчлэн, тогтсон үг хэллэгийг орчуулах амаргүй байдаг. Хэлц үг, зүйр цэцэн үгс, онигоо, тоглоом шоглоом болгосон үг хэллэгүүдийг орчуулах нь хамгийн хэцүү. Барууны улс төрчид Библиэс ишлэл татах дуртай байдаг. Тэгтэл орчуулга хийж буй нэгэн нь Библийг мэдэхгүйгээр, огт уншиж үзээгүй байгаад орчуулбал инээдтэй, эвгүй байдалд орох нь олонтаа. Тиймээс бичгийн болоод аман орчуулгын аль алинд нь өргөн мэдлэг, уужуу ухаан, их чадвар дадал шаардлагатай байдаг ажээ. Аль ч үед дипломат баримт бичиг нь харилцан хүндэтгэлийн илэрхийлэл болж байв. (Цолмон, 2010)

Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагуудаас гаргасан баримт бичиг, заавар зөвлөмжүүд, мөн олон улсын байгууллагуудын, жишээ нь Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын заавар зөвлөмж, дэлхийн улс орнуудын төр засгийн тэргүүнүүдийн хэлсэн үг, мэндчилгээ, төр засгийн болоод өндөр дээд албаныхны солилцсон бичиг, хэлсэн үг зэргийг дипломат баримт бичгүүдийн төрөл зүйлд мөн хамааруулж авч үздэг.

НҮБ-ын албан ёсны буюу ажлын 6 хэл байдаг бөгөөд англи хэлийг одоогоор олон улсын харилцааны гол хэл гэж үзэж байна. Хэл шинжээчдийн тооцоолж буйгаар одоо дэлхий дээр хятад хэлээр хамгийн олон хүн ярьж байгаа боловч ирээдүйд араб хэл олон улсын харилцаанд хүч түрэн орж ирнэ гэсэн таамаглал дэвшүүлдэг.



Arabic				
Chinese				
English				
French				
Russian				
Spanish				

Дүгнэлт

Дипломат баримт бичиг, дипломат албаны үг хэллэг нь түүхэн тодорхой цаг үе, үйл явдал болоод олон улсын харилцаа, аливаа улс гүрний хүчин чадал, соёлтой холбогдон шинэ хэлбэр, агуулгаар баяжиж ирсэн бөгөөд энэ нь олон улсын харилцааны уур амьсгал, дэлхийн эрх зүйн тогтолцоотой уялдаатай агаад шинэ нэр томьёо үүсч, шинэ үг хэллэг, санаа төрж төлөвшдөгтэй холбоотой юм.

Аливаа орчуулгыг зөв, оновчтой хийх нэг чухал арга зам нь тухай орчуулга хийж буй хоёр хэлний хэлзүй, үгсийн сангийн утгыг сайн мэдэх явдал байдаг. Англи хэлэнд ганц хоёр үгээр, эсвэл, товчилсон цөөн үсгээр илэрхийлж байгаа олон нэр томъёо, товчлол зэргийг монгол хэл рүү орчуулахдаа дээрх жишээнүүдэд дурдсан маягаар, өөрөөр хэлбэл, дүйлгэх, тайлбарлах аргаар хөрвүүлэн буулгах нь зүйтэй юм. Ялангуяа дипломат албаны, дипломат баримт бичгийн үг хэллэг, нэр томъёог орчуулахдаа зөвхөн үгийн утгыг төдийгүй, тухайн үг хэллэг үүсэн гарсан үеийн түүхэн үйл явдлуудыг сайтар судалж, мэдэж байж орчуулбал оновчтой, зөв орчуулах бүрэн боломжтой юм.

Ном зүй

1. Ц. Алтангэрэл “Дипломат баримт бичгийн орчуулга”. УБ., 2007
2. Н. Амар-Амгалан “Орчуулгын зарчмын асуудалд”. “Орчуулах Эрдэм III” Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл
3. G.R. Berridge and Alan James “A Dictionary of Diplomacy”. second edition, Palgrave Macmillan, Great Britain
4. Д. Цолмон “Дипломат ёс горим, ёслол, баримт бичиг” (Гадаад бодлого, дипломат ажиллагааны зарим асуудал). УБ. 2010.